

Солонгосын хойгт итгэлцэл бий болгох арга зам: Европийн сургамж

Марко Милани*

Товчлол: Энэхүү илтгэл нь хэлэлцээрийн үндсэн дээр Хоёр Солонгосын хоорондох харилцан итгэлцлийг байгуулах, үндэсний нэгдлийг хангах үйл явцыг Европын хувилбартай адилтган үзэж, жишээн дээр харьцуулан тайлбарласан юм. Мөн Хоёр Германы нэгдсэн үйл явцыг цөөн хэдэн тодорхойлолтоор дурдах болно. Солонгосын хойгтой төстэй мэт боловч Хоёр Германы асуудал нь 38 дугаар өргөргийн хуваагдалдай агуулгын хувьд төдийлөн таарахгүй байна. Түүнчлэн нийгэм, эдийн засгийн хөгжил болон дотоод бодлогын ялгааны талаарх Солонгосын хувьд чухал хүчин зүйл нь төрөл бүрийн хэлбэрээр нэгдэх боломжуудаа алдсанд оршино. (жишээ нь Остполитик, Хельсинк процесс)

Хэрэв Европоос сургамж авч болох зүйлүүдийг Хоёр Солонгосын нэгдэлд ашиглаж чадвал энэ нь хуваагдалт болон их хэмжээний сөргөлдөөний үед эх газрын итгэлцэлийн үйл явцуу эргүүлэхэд илүү дөхөм болно. Энэ утгаараа Европ дахь тухайн цаг үеийн хоёр том хүч оролцсон Хельсинкийн хэлэлцээрийн үйл явц нь Солонгосын Хойг дахь итгэлцэлийг бий болгоход гол чиглэл болж чадна гэж үзэж байна.

Би энэ илтгэлдээ Хельсинкийн процессийн эхлэл болон цаашдын хөгжлийг судлах ба тухайн цаг үеийн Европын нөхцөл байдлыг тодруулах

* Докторантур, Каклиари Их Сургуулийн орчин үе, өнөө үеийн түүх, олон улсын, улс төрийн салбар

болно. Мөн гарааны өөр өөр шатнаас эхэлсэн ч гэлээ хэлэлцээрийн үеэр талууд ямар сонирхолтой байсныг гаргах ба чухалд тооцогдох хамтын баримт бичгүүд дээр гарын үсэг зуруулахын тулд хурлын бүтэц ямар байсныг дурдах болно. Эцэст нь энэ үйл явцын бодит үр дүнгийн талаар, ялангуяа талуудын хооронд өндөр түвшиний итгэлцлэлийг хэрхэн бий болгосон тухай өгүүлэх зорилго оршино.

Дараа нь Солонгосын хуваагдлын талаарх судалгаанд хандаж, Хүйтэн Дайны үеийн Европын нөхцөл байдлыг Солонгосын Хойгтой харьцуулж, төстэй болон ялгаатай талыг өгүүлэх болно. Түүнчлэн Солонгосын хойг дээрх харилцан итгэлцлийг бий болгоход ямар туршиллагууд байж болохыг харуулна.

Оршил

БНСУ-ын ерөнхийлөгч И Мён Пакийн Хойд Солонгостой холбогдох бодлого нь 5 жил зогсонго байсны эцэст 2012 оны шинэ ерөнхийлөгчийн компанит ажлаас эхлэн Солонгосын хойгийн итгэлцлэлийг бий болгох процесс дахин явагдаж эхэлсэн.

2007 оны И Мён Пак ерөнхийлөгчийн сонгуулийн дараа 10 жил үргэлжлээд байсан Хоёр Солонгосын найрсаг харилцаа уналтанд орсон. Түүний жилүүдэд Хойд Солонгос руу чиглэсэн бодлогын хэрэгжүүлэлт нь шүүмжлэлтэй байсан боловч сөргөлдөөнөөс зайлсхийхийн тулд, тасраад байсан хамтын ажиллагааг эхлүүлэх хэрэгтэй болсон. Мөн харилцан итгэлцлэлийн суурийг сайн тавихын тулд хэлэлцээрийн олон хэлбэрийг ашиглах нь зүйтэй гэж үзсэн. Дахин нэгдэх урт хугацааны зорилго өнөөг хүртэл байгаа боловч гол нь Үндэсний Эвлэрлийн эхлэлийг тавих явдал юм. Ингэснээр 1953 оны гал зогсоох гэрээнээс хойш энх тайван дахин тогтоход нөлөөлөх боломж нээгдсэн.

И Мён Пак ерөнхийлөгч нь анхнаасаа илүү шийдэмгий бодлого баримталж байсан. Нарны элчийн бодлогоос татгалзсан нь Өмнөд Солонгосын сонгогчдын дунд нэр хүндээ алдахад хүргэсэн. Түүний компанит ажил нь Хойд Солонгост чиглэсэн бодит харилцааны хүрээнд АНУ-тай хамтрахад хүчтэй анхаарч байв. Төлөвлөгөөнд тусгагдсан дараагийн шат нь хоёр Солонгосын хоорондох хатуу харилцаа болон Пёнъяний цөмийн хөтөлбөрийг нааштай шийдвэрлэх асуудал байв.

2010 онд болсон Ёнпёндү болон Чонаны мөргөлдөөний улмаас байдал бүр дордсон. 3 сарын 26 өдөр Чонан хөлөг живж 46 усан цэрэг амь үрэгдэв. Хэдэн долоо хоногийн дараа Өмнөд Солонгосын удирдсан олон улсын мөрдөн шалгах ажиллагааны комиссын мэдээгээр Хойд Солонгосын шумбагч онгоцноос пуужин харвасан гэдгийг албан ёсоор мэдэгдсэн. Гэвч Хойд Солонгос үүнийг эрс няцаасан тул одоог хүртэл яг юу болж өнгөрсөн нь эргэлзээтэй үлдэв.

2010 оны 11 сард Хойд Солонгосоос Өмнөд Солонгосын Ёнпён аралруу их буугаар буудсаны улмаас хоёр иргэн, хоёр цэрэг алагдсан. Энэ нь хоёр Солонгосын хэлэлцээрийг үгүй хийж урт хугацааны турш сөргөлдөхөд хүргэсэн.

И Мён Пак ерөнхийлөгчийн засгийн газар нь болсон хоёр тохиолдлын төлөө Хойд Солонгосоос албан ёсны уучлалт гуйхыг шаардсан боловч Хойд Солонгос үүнийг нь эрс няцаан, татгалзсан хариу өгөв. Ингэж эрс татгалзсан нь нөхцөл байдлыг таагүй болгож ерөнхийлөгчийн үлдсэн хоёр жилийн хугацаанд дайсагнасан, түгшсэн байдал хэвээр хадгалагдав.

И Мён Пакийн энэ хатуу байр суур нь Өмнөд Солонгосын олон нийтийн дунд нэр хүндээ бага багаар алдагдахад хүргэсэн ба улмаар сонгогчдын хандлага нь эрх баригч консерватив намын нэр дэвшигчид шилжих нь гарцаагүй болов.

2012 оны ерөнхийлөгчийн сонгуулиар гол нэр дэвшигчид нь хойг дээрх итгэлцлэлийг төрүүлэхэд чиглэн ухуулга явуулж эхэлсэн. Хэдийгээр ардчилсан хөдөлмөрийн намын нэр дэвшигч Мүн Жэ Иний санал болгосон Оновчтой Тохиролцооны шинэ арга барилд сонгогчид ихээхэн найдвар тавьж байсан боловч консерватив намын нэр дэвшигч Пак Гён Хэгийн “Хоёр Солонгосын Трастполитик” хэмээх уриа нь илүү их сонирхол төрүүлж чадсан.

Энэ шинэ бодлогын хэрэгжилт болон үр дүнгээс гадна Хойд Солонгосын гурав дахь цөмийн туршилт, хэдэн сарын турш үргэлжилсэн сөргөлдөөн болон өдөөн хатгалгууд явагдаж байсан ч гэсэн Хойг дээрх харилцан итгэлцлэлийг байгуулах шинэ хэлбэрийг эрэн хайх нь засгийн газар болон олон нийтийн дунд газар авч байсан

нь сонирхол татна. Шинэ стратеги, шинэ арга замаар хэлэлцээрийг нээн, идэвхтэй бодлого явуулах, Сөүл, Пёнъян хоёрын хооронд шууд харилцаж болох оновчтой арга барилыг хайх нь одоо өрнөөд буй асуудлуудыг зохицуулахаас илүүтээгээр бодлогын хувьд зүйтэй санагдана.

Нэгдэл: Солонгос, Герман

Солонгосын хойгийн нөхцөл байдлыг харвал хоёр Солонгосын хоорондын сөргөлдөөнийг үгүй хийн дахин нэгтгэх талаар анхны болоод бодитоор харагдах жишээ нь мэдээж Герман юм. Дэлхийн хоёрдугаар дайны дараа улсууд хуваагдаж хүйтэн дайн дуустал дэлхий хоёр туульд хуваагдсан байв. Зөвлөлт Холбоот Улсаар хамгаалуулж, дэмжигдсэн коммунист дэглэмтэй улсууд, АНУ-ын хамгаалалтан дор барууныг дэмжигч улсууд. Хамгийн анхаарал татам жишээ бол Герман бөгөөд 1989 оны 11 сарын 9 өдөр Берлиний хана нурж, бараг жилийн дараа буюу 1990 оны 10 сарын 3 өдөр хоёр Герман нэгдэж дахин нэг улс болсон явдал юм.

Эдгээр төстэй тохиолдлууд нь хоёр Германы нэгдэл болон хоёр Солонгосын тохиолдлыг харьцуулах сонирхолыг төрүүлж байна. Гэвч Германд болсон явдлыг илүү ойроос харвал цөөн хэдэн ялгаа ажиглагдана. Яагаад Европийн тохиолдол нь боломжтой боловч алс дорнодын тохиолдол нь боломжгүй вэ гэдгийг тайлбарлаж болох юм.

Миний хамгийн эхний ажигласан зүйл гэвэл, Берлиний хана нураад 25 жилийн нүүр үзлээ. Дэлхийн хүйтэн дайн дуусан, хүчний хувьд хуваагдаад байсан хоёр тууль задран, нэгдмэл нэг байдлаас олон талт балансд шилжиж буйг бид харж байна. Олон улсад цэрэг дайны болон үзэл бодлын сөргөлдөөн намжсан боловч хоёр Солонгосын эдийн засаг, нийгмийн хүчин зүйлийн хувьд ялгаа нь илүү хурдацтай өсөж байна.

Хоёр Герман нэгдэхээс өмнөх үе болон одоогийн хоёр Солонгосын үеийн зарим үзүүлэлтийг харьцуулж үзвэл ялгааг нь илүү тод харж болно. БНАГУ нь ХБНГУ-аас жижиг(108,333 км² ба 248689 км²) ба хүн ам нь бага зэрэг илүү байсан. Хойд Солонгос нь Өмнөд Солонгосыг бодвол том(122,762 км² ба 99,173 км²) ба хүн ам

нь Өмнөд Солонгосын хүн амын бараг тэн хагастай нь тэнцүү. Эдийн засгийн үзүүлэлт нь илүү доогуур гардаг. Тухайлбал Зүүн Герман нь Баруун Германыг бодвол ядуу бөгөөд 1989 оны ДНБ нь Бонн хотын ДНБ-ий 17%, нэг хүнд ноогдох ДНБ нь 60%-иас доогуур байсан. Хоёр Солонгосын хувьд бүр илүү их ялгаа харагддаг. Тухайлбал Хойд Солонгосын ҮНБ нь Өмнөд Солонгосын ҮНБ-ий 2.5%-тай, нэг хүнд нөөгдөх ҮНБ нь 5.3%-тай тэнцүү байна.

Өгөгдсөн статистикийн баримтаас харвал одоо цаг үед Германы жишгээр Хоёр Солонгос нэгдвэл Сөүлд хүнд тусна. Үнэндээ Хоёр Герман бол нэг нь нөгөөдөө ууссан шинжтэй нэгдэх үзэгдэл явагдсан. Берлиний хана нурж Герман улс дахин шинэчлэгдэн нэг улс болсон бөгөөд Зүүн Германы таван муж Баруун Германы бүрэлдхүүнд багтсан төдий үйл явц байв.

Хүйтэн дайн дуусахын сацуу дэлхийн улсуудын дахин нэгдэх боломж бүрэлдсэн боловч Солонгосын хойгийн хуваагдалт нь улам гүн ялгаатай болсоор байв. Хэдийгээр Америк, Зөвлөлтийн өрсөлдөөний улмаас дэлхий ертөнц хуваагдаж байсан ч гэлээ хоёр Солонгосын хувьд огт өөр асуудал байв.

Нэгдүгээрт. Дайны дараах хуваагдлаас шалтгаалан Солонгосын хойгт гадны нөлөөнөөс улбаатай иргэний жинхэнэ дайн дэгдсэн. Үлмаар 1950-1953 онуудад Солонгосын дайн болж урт хугацааны турш эвлэрэх боломжгүй хоёр улс болгон хуваахад хүргэсэн. Хоёр Солонгосын харилцаа нь 1972 оны хамтарсан тунхаглал гаргах хүртэл 38 дугаар өргөргийн хооронд ямарч харилцаагүй байв. Яг энэ үед Хоёр Герман болон Социалист эвсэл, Боннийн хоорондох харилцаа илүү эерэг хандлагатай болж ирсэн. Үүнийг дараа дэлгэрүүлэх болно.

Мөн түүнчлэн Солонгосын дайны дараагаар Солонгосын нөхцөл байдал Европын асуудалтай харьцуулахад хамаагүй тусгаарлагдмал, ганцаардмал орчинд байсан тул Пёнъян дотоод хүчээ зузаатгах бодлого явуулахад хүргэсэн бол Зүүн Герман нь АНУ-ЗХУ хоорондын динамикаас шалтгаалан “Илүү их анхаарлын” төвд байсан бөгөөд Зүүн Германы бодлогод Москва Вашингтоны харилцааны өөрчлөлт нөлөөлдөг байв.

Хоёр туульт нийгмийн тогтолцоонд хуваагдаж байдаг улсууд харилцан нэг нэгэндээ буулт хийж эхэлсэн цаг үеийн Германы асуудалд хандсан гадаад оролцоо маш чухал байр суурь эзэлж байсан бол Солонгосын асуудалд бараг хэн ч оролцоогүй байна. Солонгосын хойг дахь гол өөрчлөлт нь Никсоны онолыг тунхаглан зарласан үе болон Хятад Америкийн харилцаа сайжирсан үеэс эхэлсэн.

Эцэст нь Бээжингийн оролцоог доогуур үнэлж болохгүй. Хүйтэн дайн төгсөж Зүүн Европын социалист дэглэмтэй эдийн засаг болон стратегийн цорын ганц гол хамтрагч нь бууж өгсөнөөр дээрхи улсуудад улс төрийн шилжилт хийх нөхцөлийг бүрдүүлсэн.

Зүүн Азид Хятад улс өөр бусдаас өөр нийгмийг байгуулсан ба Пёнъяны хувьд энэ нь амь зогоох боломж болсон. Гол хамтрагчийнх нь сүр хүч буурч эхэлсэн ч Хойд Солонгос нь Бээжингийн засгийн газрын газар зүйн, улс төрийн болон газар нутгийн ойр байдалд нь найдаж болохоор байв.

Үүний дараа Америкийн цэрэг байрлах өмнөд хэсэг болон 38-р өргөргийн хилийн хооронд байрлах түүх болон үзэл суртлын шалтгаанаас үл хамаарсан бамбай улс хэрэгтэй болов.

Дэлхий ертөнцөд шинээр төрөн гарч ирж буй нэгдмэл хүч болох АНУ хэмээх цорын ганц том хүч хэвээр үлдсэн цаг үед буюу 1989 оны Тианнамены хэрэг явдлаас хойш Вашингтоны засаг захиргаа Хятадын системд таагүй ханддаг болсон тул Бээжингийн удирдлага хилийн зааг болон АНУ-ын цэргийн хооронд бамбай улс байгуулах хэрэгтэй болсон.

Дээрхи түүхийн болон улс төрийн товч анализ, дүгнэлтийг харвал, олон улсын харилцааны тавцанд Хүйтэн дайны төгсгөл иргсэн ч гэлээ Солонгосын Хойгийн хуваагдал хэвээр хадгалагдан үлдсэний учрыг ойлгож болно.

Эдгээрээс гадна өөр нэг шалтгааныг мөн судлах хэрэгтэй. Дээр дурдагдсан хоёр улсын хоорондох ялгааг Германы хувьд авч үзвэл олон төрлийн зохион байгуулалттайгаар холбоо тогтоох боломж үүссэн нь нэгдэх боломжыг түргэсгэж өгсөн. Үнэндээ Хүйтэн Дайны дараах үе болон нэгдэх боломжыг ашиглахад бэлэн байсан зэрэг нь давхцаж таарсан юм.

Энэ утгаараа Социал Демократ Канцлер Вилли Брантдын эхлүүлсэн бодлого болон түүний орыг залгамжлагчид арай өөрөөр буюу Остполитик нэрээр үргэлжлүүлсэн нь чухал үүрэг гүйцэтгэсэн.

Хүйтэн дайны төмөр хөшиг 20 гаруй жилийн туршид байсан боловч Хоёр Германы харилцаа ба Баруун Герман, Социалист улсуудын хоорондын эдийн засаг, соёлын солилцоо, өндөр түвшны яриа хэлэлцээр, улс төрийн харилцан бие биенээ хүлээн зөвшөөрсөн хандлага зэрэг нь хоорондын зааг ялгааг нөхөж байв.

Цэвэр Герман маягийн Остполитик санаачлага нь Европ тивд хоёр блокыг ойртуулах, цаашлаад хоёр Германыг нийлүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн. Буулт хийж хамтрах процесс явагдаж байх үе нь Хельсинкийн Гэрээг зурах нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Харин Солонгосын хойгийн тухайд болон хоёр Солонгосын хувьд хоёр Германы хооронд бий болсон Остполитик гэхээр зүйл ч байхгүй олон улсын түвшинд ч Хельсинкийн Конференц гэхээр ямар нэгэн зүйл байхгүй байна. 1972 оны Хоёр Солонгосын хамтарсан тунхаглал нь стратегийн гэхээсээ илүүтэйгээр тактикийн нүүдэл байсан бөгөөд богино хугацаандаа ямар нэгэн нөлөө бараг байгаагүй. Харин Ро Тэ Воны эхлүүлсэн Нордполитик бодлого нь (Брантдын санаачлагатай илт төстэй үгтэй) хэтэрхий оройтсон бөгөөд Остполитик шиг тийм хэмжээний жинтэй стратеги байгаагүй.

Хэрэв Германы жишээ нь Солонгосын Хойгт хэрэглэгдэх үр өгөөжтэй арга биш юм бол өнөөдөр ч 90-ээд онд ч Герман болон Европын жишээг Хоёр Солонгосын хооронд үр өгөөжтэй итгэлцэл бий болгоход хэрэглэж болохгүй гэсэн үг юм.

Итгэлцэхэд санаа авах зүйлс: Остполитик болон Хельсинки

Хүйтэн дайны үр дүнд Европын газар нутагт Германы Остполитикийн туршлага бий болох үед тодорхой хэмжээний энерги бий болсон. Хоёр туйлт хүч нь хоёр блокын хооронд дайсагналцлыг бий болгосон төдийгүй тодорхой хэмжээний тэнцвэрт байдлыг бий болгосон. 1961 оны Берлины хямрал болон хоёр Германыг тусгаарласан хана баригдснаас хойш нөхцөл байдал ихээхэн хүйтэрсэн.

1966-1969 оны Их Эвслийн үед гадаад хэргийн сайд байсан Канцлер Брантдын анхаарал 60-аад оны үед Баруун Герман болон Социалист орнуудтай бий болсон эдийн засаг болон худалдааны холбооноос анхаарлаа түр холдуулснаар харилцаа тогтоох бодлогыг нэг шат илүү ахиулсан.

Барих бодлогоос үүдсэн хөдөлгөөнгүй байдлыг арилгахын тулд эхлээд хоёр орны нэгдлийн тухай асуудлыг түр азнаж хоёр Герман болон Бонн, Социалист орнуудын харилцааг сайжруулахад голчлон анхаарч эхэлсэн. Канцлерын үзлээр энэ маягийн оролцооны бодлого нь хэтдээ хоёр улсын нэгдлийн үндсэн суурь нь болно гэж найдаж байв. Тэрээр энэ зорилгоор ЗХУ-тай эдийн засаг соёлын харилцан солилцоог улам гүнзгийрүүлж, ЗХУ болон Зүүн Европтой хэд хэдэн хэлэлцээрийг эхлүүлж харилцан улс төрийн нэг нэгнээ хүлээн зөвшөөрөх байдлыг бий болгож чадсан.

Хэдийгээр Остполитик нь Брандтай салшгүй холбоотой боловч урьдын Баруун Германы үе үеийн засгийн газрууд Зүүн Германтай бий болгосон харилцаа холбоогоо таслахгүйг хичээж ирсэн бөгөөд тус улсад үзүүлдэг санхүүгийн дэмжлэгээ үргэлжлүүлэн үзүүлсээр байсан. Энэ төрлийн оролцоогоо хадгалж үлдэн хорин жилийн дараах Зөвлөлтийн удирдагч Горбачёвын хийсэн өөрчлөн байгуулалтаар Хоёр Германы нэгдэлд хүргэх боломжийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн.

Баруун Германы засгийн газрын хүсэн хүлээж бий болгосон Остполитик хэмээх бодлого нь түүний холбоотнуудын дургүйг хүргэсэн. Гэвч тухайн үед Европод Итгэлцлэлийг байгуулсан өөр нэгэн жишээ гарч ирсэн. Энэ нь АНУ, ЗХУ-ын стратегийн түншлэл болон Европын бүх улсуудын хамтарсан олон талт үйл ажиллагаа юм.

Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар хил зааг, тусгаар тогтнол болон харилцан нэг нэгнээ хүлээн зөвшөөрөх талаар Пан-Европын энхийн гэрээ хараахан хийгдээгүй байлаа. Нацист Германыг ялсаны дараагаар хүчнүүдийн бий болгосон Статус Кво хөдлөшгүйгээр улам бэхжсээр байв. Холбоотон хүчнүүд энхийн ямар ч гэрээ хэлэлцээрийг үл сахисан төдийгүй хоёр системийн хоорондын эцэс төгсгөлгүй

дайсагналцал үргэлжилсэн. ЗХУ болон АНУ нь уг асуудлыг улам дэвэргэсээр байлаа.

Учир иймд Хельсинкигийн конференц нь түүхэн утгаараа ч газар зүйн байдлаасаа ч олон жилийн туршид олон улсын түвшинд өрнөөгүй үйл явдал бөгөөд Ялтын гэрээ мэт үнэ цэнэтэй гэж хэлж болох юм. Варшавын гэрээний орнуудын санал болгосноор 1969 онд Финляндын санаачилсан Европын Аюулгүй байдал болон Хамтын ажиллагааны Конференц нь 1972-1975 онуудад оргил цэгтээ хүртэл хөгжсөн юм. Сүүлийн акт бичиг болох Хельсинкигийн сүүлийн акт бичигт Албани, ЗХУ, АНУ, Канад зэрэг улс оролцоогүй.

Хамгийн чухал зүйл болох сүпер хүчнүүдийн үндсэн оролцоо болон тэмцэлдээнийг хэлэлцээрийн аргаар шийдсэн нь эцэстээ Пан Европын энхийн хэлэлцээр хийхэд хүргэж чадсан.

Мөн түүнчлэн Остполитик болон Хельсинкийн конференцийн үйл явцыг тусад нь авч болохгүй юм. Олон талаас нь судалж үзвэл энэ хоёр үйл явдал нь хоёулаа үнэн хэрэгтээ нэг ижил хэрэгцээ шаардлага болон нэг ижил зорилготой байсан байна. Баруун Герман болон Европийн зарим улсын урт хугацаан дахь зорилго нь удаан хаалттай байгаа төмөр хөшгийг өөрчлөж, энэ тив дээрхи хурц хуваагдлыг арилгахад оршиж байсан боловч энэхүү зорилгодоо хүрэхийн тулд Статус квог богино хугацаанд дэмжих хэрэгтэй байсан. Статус квог илүү амьд болгохын тулд модус вивенди (Modus vivendi-Үзэл бодол өөр боловч нэгнээ хүлээн зөвшөөрч амьдрах арга)-г сайжруулснаар алсдаа өргөн хүрээний системийн өөрчлөлтийг авчрах болно гэж үзсэн.

Энэ утгаараа Европын Аюулгүй байдал болон Хамтын ажиллагааны Конференц нь Остполитикийн өсгөгч нь ч гэж хэлж болохоор юм. Өөрөөр хэлбэл хоёр талт харилцааны хэлбэрээс (Зүүнтэй харилцах шинэ харилцааг Баруун Герман дэмжсэн) олон талт буюу Европын бусад улс орнууд, хоёр стратегийн хүчнүүдийн хооронд харилцаа үүссэн.

Хельсинкийн конференсийн эдгээр тайлбарууд дээр нэмж хэлэхэд үйл явдалын талаарх маш өөр зорилго, хүсэлтэй маш өөр хүмүүсийн олон талт харилцаа нь сүүлийн актанд гарын үсэг зурах хүртэл хадгалагдсаар байсан.

Хоёр том хүч энэ харилцаанд өөр өөрсдийн стратегийн учир шалтгааны улмаас нэгдсэн. Дэлхийн хоёрдугаар дайны нацизмын ялагдлын дараагаар бий болсон хил хязгаарыг “хуульчилж”, тодорхойлох боломж гэж ЗХУ энэхүү конференцийг харсан. Мөн түүнчлэн баруун болон зүүн Европын хооронд улам бүр эрчимжиж буй хэлхээ холбоог барьж тогтоох нэг төрлийн бүтэцтэй боллоо гэж харж байлаа. Харин АНУ нөгөө талд Хельсинкийн конференцийг ЗХУ-тай хурцадмал байдлаа намжаах томоохон төсөл гэж харж байсан. Тэр тусмаа холбооны онолоор бол төрийн нарийн бичгийн дарга Хенри Кессинжерийн хувьд энэ маш чухал төсөл байсан юм. Зэвсэглэлээр хөөцөлдөх болон цөмийн зэвсгийн тухай Москвагай яриа хэлэлцээрт ороход гол суваг болох боломжтой гэж АНУ харсан.

Мэдээж Европын улс орнуудын хувьд намжмал үйл явцын нөлөөнөөс болж нөхцөл байдал их өөр байсан. Баруун Европын орнуудын хувьд хүйтэн дайны уршгаар бий болсон статус-квог сайжруулж, энэ тив дээр бий болсон хуваагдлыг арилгах, үгүй ядаж хязгаарлах боломж хэмээн харж байлаа. Харин зүүн европын орнуудын хувьд Хельсинки бол баруун дахь хөршүүдтэйгээ хэлхээ холбоо бий болгох тэр дундаа эдийн засгийн харилцаа тогтоох боломж гэж харсан.

Энэ олон зорилгуудын хажуугаар конференцийн өөрийнх нь бүтэц нь эерэг үр дүн авчрахаар зохион байгуулагдсан байлаа. Яг эндээс нь нэгэн чухал сургамж хэрэгжүүлж болох зүйл урган гарсан бөгөөд өөр бусад нөхцөл байдалд чухамхүү Солонгосын нөхцөл байдалд ч үр өгөөжөө өгөх нь дамжиггүй.

Хельсинкигийн хэлэлцүүлэг буюу конференцийн өмнөх бэлтгэлт уулзалтаар ярилцах гол асуудлаа илэрхийлдэг байсан. Яг энэ үеэр уулзалтуудын горимыг боловсруулах, конференцийн хөтөлбөрийн төслийг бэлтгэх мөн хэлэлцүүлгийн хэлбэрийг бий болгосон. Хэлэлцүүлэгт оролцогчид конференцид оролцохгүй байхаар мөн шийдсэн. Ингэж гэмээн туршилтын энэ шатанд оролцож буй талууд конференцид оролцоход хөл гарыг нь хүлэхгүйгээр чөлөөтэй байх нөхцөлийг бүх засгийн газруудад олгосон байна.

Хэлэлцүүлгийн зорилго нь Конференцийг тодорхой хэмжээний амжилттай болгох ирээдүйг бэлтгэхэд оршиж байсан. Маш нарийн бэлтгэл ажлыг хангах, урьдач нөхцөлийг аль нэг тал бусаддаа ноогдуулахгүй байх, европын дэвжээн дээрхи бүх талуудыг харилцан тэгш хэм хэмжээнээс оролцох нөхцөл боломжийг бий болгоход оршиж байв.

Мөн нэг чухал зүйл нь энэхүү хэлэлцүүлгийн хэлбэр байсан юм. Консенсусийн буюу санаа нийлэхийн зарчмыг баримталж байсан. Хэн нэгэн шууд эсэргүүцээгүй бол шийдвэрт хүрнэ. Хэрэв оролцогч арга хэмжээг зогсоохыг оролдвол улс төрийн маш том төлөөс төлөх хэрэгтэй болох бөгөөд бүх яриа хэлэлцүүлгийг замаас гаргана.

Конференцийг зохион байгуулахад хэрэглэсэн энэ бүх арга хэмжээ нь Европын орнуудын хооронд итгэлцэл бий болгоход чиглэсэн томоохон зорилгодоо хүрч амжилтанд хүргэсэн.

Эдгээр арга хэмжээн дээр нэмээд Хельсинкийн танилцуулсан бас нэг шинэлэг санаа нь Baskets буюу сагсны концепц юм. Хэлэлцүүлэг болон хэлэлцээрийн үеэр олон төрлийн асуудлыг хуваагаад гурван өөр сав буюу сагсанд хийдэг байсан. Ингэснээр тухайн нэг асуудал дээр санал зөрөлдөөн гарвал энэ нь бүх найрсаг яриа хэлэлцээрийг сүйтгэхгүй байх боломжтой болдог. Үнэндээ сагснууд хоорондоо ямар нэгэн шууд холбоогүй байсан учраас маш олон санал зөрөлдөөнтэй асуудлыг, тухайлбал хүний эрхийн асуудлаас байнга жийрхэж байдаг улсуудыг энэ асуудлыг хэлэлцэхгүй өнгөрөхгүй байлгах боломжтой болсон юм. Хельсинкийн процессын үеэр сагснуудыг гурав хуваадаг байв. Аюулгүйн асуудал (итгэлцэл төрүүлэх арга хэмжээ, зарчим ба биеэ авч явах журам), Эдийн засгийн асуудал (байгаль орчны болон технологийн хамтын ажиллагаа үүнд мөн багтсан) мөн хүний эрх. Энэ сагснууд дээр нэмэгдээд өмнөх Конференцийн үеэр хэлэлцсэн асуудлуудыг багтаасан сагс ордог байв.

Энэ төрлийн зохион байгуулалт нь 1975 онд Эцсийн хэлэлцээрийг батлахад маш чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Пан-Европын энхийн хэлэлцээрийн орыг залгагч ч гэж хэлж болохоор Хельсинкийн процесс нь Европын дэвжээн дээрх сөргөөлдөөнийг намжаах шинэ, иж бүрэн, тогтвортой бүтэц нь яриа хэлэлцээр болон санал солилцох

шинэ сувгийг бий болгосон бөгөөд нь энэ нь яваандаа эерэг өөрчлөлт авчрах суурь нь болсон. Энэ үеэр хилийн халдашгүй байдлын зарчмыг баталж (энэ нь ЗХУ-ын хувьд амин чухал байсан), харилцан санал нийлсэн болон энхийн өөрчлөлтөөр дамжуулан өөрчлөлт хийх боломж (ирээдүйн Германы нэгдлийн эхлэл үүнээс үүдэлтэй). Эцэстээ хэлэлцээрийн энэхүү урт процесс болон бүтэц нь олон улсын харилцаа болон олон талт хандлага, наанадаж Европын талбарыг ардчилсан болгох боломжийг нээсэн.

Эдгээр чухал үр дүн дээр нэмэгдээд гуравдахь сагс буюу хүний эрхийн асуудал нь эхэндээ энэхүү конференцийн гол асуудлуудын нэг биш байсан боловч эцэстээ уулзалтын хөтөлбөрийн маш чухал асуудал болж хувирсан бөгөөд социалист блокын олон орнуудын тэрслүү үзэлтнүүдийн хэрэглэх чухал нэгэн зэвсэг нь болж өгсөн.

Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш биеэ барьсан, хөлдөнги харилцаанаас давж оролцооны бүтэц болон харилцан итгэлцэлийг бий болгоход Остполитик (хоёр талын харилцааны үүднээс) болон ЕАБХАК(тодорхой хэмжээний олон талт харилцааны үүднээс) нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн гэдгийг бид сая олж харлаа. 70-аад оны Европын энэ туршлагын энхүү шинж чанар нь Солонгосын хойг дээр шинээр итгэлцэлийг бий болгох процессыг хурдасгах томоохон эх сурвалж болж байгаа юм.

Европоос Солонгос руу: Итгэлцэл бий болгох шинэ процесс

Оролцогч талуудын хооронд итгэлцэлийг бий болгоно гэдэг амаргүй ажил. Яг үүнтэй ижил итгэлцэл гэж яг юуг тодорхойлох, мөн түүндээ хэрхэн хүрэхийг тогтооно гэдэг амаргүй. Итгэлцэлийн нэг онцлог нь эрсдэлийг илэрхийлдэг бол тэрхүү эрсдэл нь нөгөө талынхаа зан авирыг яг таг мэдэхгүй байгаад оршдог. Тийм учраас бидний үйлдэл нь энэхүү эрсдлийг дэнслэж үзэх ёстой болдог. Мөн түүнчлэн оролцогч талуудын эрх тэгш байдал чухал яагаад гэвэл хэрвээ нэг нь нөгөөгөөсөө дээгүүр байвал итгэлцэлийн харилцаа нь ямар ч ашиггүй болж эрх мэдэл нь хэвийн нөхцөл байдлыг эвддэг.

Улсуудын хоородын харилцаан дээр ч энэ бас ижилхэн. Хэрэгцээн дээр суурилсан харилцаанаас илүү итгэлэлцэл дээр суурилсан хамтын ажиллагаа нь аливаад илүү тэсвэртэй мөн удаан хугацааны байж чаддаг, өөрөөр хэлбэл эрх мэдэл бол итгэлцэлийн орлуулж болох хэвийн ажиллагаатай итгэлцэлээс тэс өөр юм. Яагаад гэвэл нэг оролцогчийн ашиг сонирхол нь нөгөө талдаа багтаж, энэхүү харилцаа нь ямагт ололт амжилттай байдаг бөгөөд зарим тохиолдолд талуудын хүлээлт биеллээ олдог.

Дайсагналцалаас болж харилцан итгэлцэл бий болох боломжгүй мэт санагдах нөхцөл байдалд итгэлцэл бий болох хэд хэдэн боломж бий. Ерөнхийдөө гурвыг энд тодорхойлж болно. Урт хугацааны суралцах үйл явц, институцуудыг бий болгох, болон хамтын зорьсон санааг бий болгох эсвэл тийм санаатай байх.

Дээрхи гурван арга хэрэгсэлийг зэрэг ашигласанаараа Остполитик болон Хельсинкийн Конференцийн туршлага давуу талтай. Эдийн засаг болон соёлын солилцоо, дипломат хэлэлцээрт гарын үсэг зурсан байдал, Хельсинкийн процессын урт яриа хэлэлцээр зэрэг нь түншүүдийн найдвартай байдлыг шалгах боломжийг олгосон юм.

Европын аюулгүй байдал болон хамтын ажиллагааны байгууллага нь оролцогч талуудын урьдчилан хэлэх боломжгүй байдлыг хязгаарлаж яриа хэлэлцээрийг бий болгох боломжийг нээсэн институцийн бүтцийг бий болгосон. Эцэст нь хэлэхэд Остполитик болон ЕАБХАК нь Европын улс орнуудын дунд бий болсон (тэр дундаа хоёр Германы хуваагдал) нийтлэг үнэт зүйл болон өвөрмөц байдал(хамтын зорьсон санаа)-ыг ил гаргахын тулд чиглэгдсэн байна.

Солонгосын хойгийн асуудал руу эргэн ороход Европын туршлагын энэхүү гурван асуудал дээр анхаарлаа хандуулбал гол зөвлөмж болох болов уу. Харилцан итгэлцэлийг бий болгох процесс нь амжилт авчрах магадлалтай бөгөөд үүнийг эхлээд ямар нэгэн урьтач нөхцөлгүйгээр яриа хэлэлцээрийг эхлүүлж талуудыг нэг ижил түвшинд аваачин талуудын амин чухал ашиг сонирхолыг авч үзэх нь чухал. Нэгдэлийн тухай ямар нэгэн битүү санаа агуулахгүй байх эс бөгөөс энэ нь аль нэг талыг алга болгоход хүргэх бөгөөд цаашид яриа

хэлэлцээрийг үргэлжлүүлэх сонирхолыг үгүй хийнэ. Остполитик шиг процессоор статус квогийн амьд байдлыг сэргээж, үүнийг богино хугацаандаа ямар нэгэн байдлаар эргэлзэхгүй байвал урт хугацаандаа системийн өөрчлөлт хийх боломжтой.

Мөн түүнчлэн Хельсинкитэй ижил төстэй процесс нь зэвсэглэлээр хөөцөлдөх байдлаас үүссэн асуудлыг даван туулах нийтлэг бүтцийг бий болгох боломжтой. Европт Пан-европын энхийн гэрээг Эцсийн хэлэлцээрээр орлуулсан шиг зүүн Азийн хувьд жинхэнэ энхийн гэрээг үзэглэсэнээрээ солонгосын дайн болон түүнд оролцсон талуудын асуудлыг бүрмөсөн хаах хувилбар харагдаж байгаа юм. Яриа хэлэлцээр болон харилцаа тогтоох институцийн системийг бий болгосоноороо Итгэлцэл болон аюулгүй байдлыг бий болгох арга хэмжээг танилцуулах боломжтой болох бөгөөд хойг дээрхи сөргөлдөөнийг намжаах тэр байтугай цэргийн түвшинд ч намжмал байдлыг авчрах боломжтой. Энэхүү процессын дунд хугацааны зорилго нь Зүүн хойд азид аюулгүй байдлын иж бүрэн болон тогтвортой системийг бий болгоход оршиж байна.

Яг хүрсэн үр дүнгээс гадна эцсийн тохиролцоонд хүргэсэн практик элементүүдийг Хельсинкийн процессоос авч болно. Маш нарийвчилсан бэлтгэл хэлэлцүүлэгүүд чухал үүрэг гүйцэтгэсэн нь дамжиггүй бөгөөд, мөн сагсны концепци зэрэг нь оролцогч олон талуудын хүсэлт болон зорилгод хүрэхэд загварчлагдсан байсан.

1987 оноос хойш Өмнөд Солонгосын консерватив болон дэвшилтэт намууд оролдож хийсэн Нордполитик жишээ нь оновчтой оролцооны өнцгөөс дэлхий дахинд өрнөж буй асуудлыг шийдэх нэг оролдлого байсан. Үүнээс ч илүүтэйгээр Нарны элч бодлогын үеэр статус квогийн амьд байдлыг сайжруулах боломжтой бөгөөд хоёр Солонгосын ойлголтыг өөрчилж олон мянган жилийн түүхэнд нэгдмэл соёлын өвөрмөц байдлыг ч эргэн харах боломжийг бий болгоно.

Солонгосын хойг дээрх итгэлцэл байгуулах процессыг бий болгохдоо Европын туршлагаас дээрхи сургамжуудыг авахын сацуу итгэлцэл бий болдог бүх гурван талбарыг оролцуулах хэрэгтэй.